



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/161

Чингис хот

Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлж,  
урьдчилан сэргийлэх арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын батлагдсан тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Галшар, Баянмөнх сумдыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан тус сумдад хатуу хөл хорионы дэглэмийг мөрдүүлж, тээврийн хэрэгслийн болон иргэдийн хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 14:00 цагаас 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 06:00 хүртэлх хугацаанд бүрэн зогсоож, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн сумдад гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албад, тусгай чиг үүрэг гүйцэтгэх төрийн байгууллагаас бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дээрх хугацаанд зогсоосугай.

4. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын батлагдсан тохиолдлын хавьтал бүхий иргэдийн судалгааг гаргаж, шинжилгээнд хамруулан хяналт тавьж ажиллахыг Тагнуулын хэлтэс /дэд хурандаа Н.Алтангэрэл/, Онцгой байдлын газар /хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

• 231010439

2.

5. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн сумдын бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл түр зогсоосугай.

6. Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Галшар, Баянмөнх сумдаас бусад сумдын нутаг дэвсгэрт өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

7. Дээрх хугацаанд Хэнтий аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйлчилгээ, олон нийтийг хамарсан хурал зөвлөгөөн, жагсаал цуглаан, соёл урлаг, спортын арга хэмжээ, үзвэр үйлчилгээ зохион байгуулах, сургалтын төв, фитнес баялдаржуулах төв, баар, ресторан, караоке, цэнгээний газар, компьютер болон биллиард тоглоомын газар, сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоосугай.

8. Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, олон нийтийн газарт зорчих үедээ гар ариутгагч хэрэглэн амны хаалт тогтмол зүүхийг аймгийн нийт иргэдэд, бараа үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон ажиллахыг хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ